

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</i>		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/		2025 оны 01 сарын 01 өдрөөс 2025 оны 12 сарын 31 өдөр хүртэл
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		"Эм жи эл агуа" ХК, 000274041, MSE: MGLA, 77045555
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын Хөрөнгийн Бирж ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Хүнсний үйлдвэрлэл, Шингэн хүнсний үйлдвэрлэл,
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		"ПИ КЭЙ ЭФ – АЙ ЭЙ ЭС Аудит" ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		327,555,616 (гурван зуун хорин долоон сая, таван зуун тавин таван мянга, зургаан зуун арван зургаа)
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: С.Алтантуяа, Б.Бат-Оргил, Б.Дашзэвэг, Д.Бат-Ирээдүй
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	

	2026.04 сард тайланг хүрүүлнэ.			
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/			
	Байхгүй			
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Харьцаанууд	2024	2025
		Нийт ашгийн хувь	51%	46%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	32%	3%
		Цэвэр ашгийн хувь	15%	2%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	9%	1%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	10.75	1.47
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Харьцаанууд	2024	2025
		Эргэлтийн харьцаа	4.9	3.49
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	0.04	0.005
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	1.15	0.2
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2024 ондгадаад валютын ханш болон инфляцийн нөлөө харьцангуй тогтвортой байсан Усны зах зээл дээрх нэр төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглэгчийн сонголтийн сонголтонд нөлөөлөх өрсөлдөөн нэмэгдэж байна. Усны зах зээл дээрх эзлэх хувийг нэмэгдүүлэхийн тулд шинэ бүтээгдэхүүн судлаж судалгааны ажил хийгдэж зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гаргахад бэлэн болсон.		
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.		
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Зээлдүүлэгч - Хас банк ХК Зээлийн хугацаа – 5 жил Зээлийн дүн – 1,522,815,485 Зээлийн зориулалт - Түгээлтийн 11 автомашин худалдан авах		

3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
	2025.03.19 өдрийн ТУЗ-ийн Т/39 тогтоолоор Өмнөговь аймагт байгуулах 4100м.кв цэвэр усны үйдвэрийн барилга, дэд бүтцийн ажлыг гүйцэтгэх зорилгоор Ньюгор ХХК-тай 7,897,649,593.1 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг Эм жи эл агуа ХК-ийн охин компани Ти эм эл агуа ХХК-д зөвшөөрөв. 2025.11.03 өдрийн ТУЗ-ийн Т/50 тогтоолоор Худалдаа Хөгжлийн Банкны барьцаанд буй компанийн хөрөнгийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрөв.
4.	Цалин урамшууллын мэдээлэл ТУЗ-ийн цалин, урамшуулал Компанийн Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан. ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2025 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй. Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна. Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна “Цэвэр борлуулалтын дүн, Борлуулалтын авлагын эргэц, Цэвэр ашиг” гэсэн гүйцэтгэлийн 3 үндсэн шалгуур үзүүлэлтийг 50*30*20 гэсэн харгалзах хувийн жинтэйгээр тооцож, улирал бүр урамшуулал боддог. Ажилтны цалин, урамшуулал Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоохоор заасан.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл “Эм жи эл агуа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025.04.23 өдөр цахимаар зохион байгуулж дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд: “Эм жи эл агуа” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав. - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөвийг батлав. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд дараах хүмүүсийг сонгов. Ердийн гишүүдэд: - С.Алтантуяа - Х.Тэгшээ


	• О.Сансар /Shansier/ • М.Дөлгөөн • Л.Билгүүн • С.Санасэр Хараат бус гишүүдэд: • Ч.Анхбаяр • Д.Басандорж • Г.Мөнх-Эрдэнэ 2025 онд компанийн төлөөлөн удирдах зөвлөл нийт 12 удаа хуралдаж холбогдох шийдвэр тогтоолыг гаргав. 2025 онд ТУЗ нь дэргэдээ 5 дэд хороодтойгоор үйл ажиллагаа явуулав. Үүнд: • Аудит эрсдлийн хороо • Нэр дэвшүүлэх хороо • Цалин урамшууллын хороо • Стратеги, Бизнес хөгжлийн хороо • Хөрөнгө оруулагчдын харилцааны хороо 2025 онд ТУЗ дэргэдэх Аудит эрсдлийн хорооноос компанийн удирдлагын багт байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх болон байгууллагын орлогын төсөөллийг тооцох талаар 3 удаа сургалт оров. 2025 онд ТУЗ дэргэдэх Хөрөнгө оруулагчдын харилцааны хорооноос компанийн гүйцэтгэлийн тайланг сар бүр mglaqua.mn вэбсайтаар дамжуулан мэдээлж ажиллав. ТУЗ дэргэдэх дэд хороодууд үйл ажиллагааны тайлангаа компанийн вэбсайт mglaqua.mn – р дамжуулан тогтмол тайлагнан ажиллаж байна. Компани 2025 онд анх удаа БОНЗ (Байгаль орчин, нийгэм, засаглал) тайлан гаргаж олон нийтэд танилцуулав. Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээ Компани олон нийтийн нээлттэй компани болсноос хойш анх удаа компанийн засаглалын кодексын 2024 оны өөрийн үнэлгээний тайланг хийж 78%-тай гарав. Цаашид компанийн засаглалын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ТУЗ дэргэдэх хороодууд идэвхтэй ажиллаж байна.
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Эрсдэлээс урьдчилан сэргийлж оновчтой удирдахын тулд шаардлагатай арга хэмжээ тодорхойлж ажиллав.Мөн урт болон богино хугацааны эрсдэлийг төлөвлөж процессийг сайжруулахын хүрээнд дотооддоо олон хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж үйлдэрлэлийн үйл ажиллагааг тасалдуулахгүйн тулд 6 давхар шүүлтүүрээ шинээр сольж хүчин чадлыг нэмэгдүүлж харилцагч хэрэглэгч ажилтан оролцогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлж ажиллаа.
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Ти эм эл трейд ХХК - 240,000,000, (73.27%) Дорж Мөнхөө - 22,883,242 (6.99%)
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

“Эм Жи Эл Акуа” ХК нь IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ашиглахаар төлөвлөсөн.

2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нийт 15,234,677,184 (арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун наядөрвөн) төгрөгийг IPO-оор амжилттай татан төвлөрүүлж, компанийн банкны дансанд хүлээн авсан болно.

2. Хөрөнгийн зарцуулалт



Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдлаар хийгдсэн байна.

2.1. Түүхий эд, материалын худалдан авалт

IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,116,812,809 төгрөгийг түүхий эд, материал (ТЭМ) худалдан авахад зарцуулсан бөгөөд уг зардлыг 2024 онд бүрэн санхүүжүүлж дуусгасан.

2.2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, трансформаторын худалдан авалт

2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам худалдан авахад 4,500,000,000 төгрөг, трансформатор худалдан авахад 550,000,000 төгрөг тус тус зарцуулсан (Зураг 1). Трансформаторыг 2025 оны дөрөвдүгээр улиралд суурилуулж дууссан.

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эхний багц болох цэвэршүүлэх (филтер) шугамыг 2025 оны 5 дугаар сарын 3-наас 5 дугаар сарын 23-ны хооронд суурилуулсан. Өмнөговийн үйлдвэрийн төслийг ашиглалтанд орох үед Улаанбаатар үйлдвэрийн шугамын тоног төхөөрөмжийг Өмнөговь үйлдвэр лүү шилжүүлнэ. Үүний дараа том савлагааны үйлдвэрлэлийн шугамын үлдсэн тоног төхөөрөмжийг 2026 оны 04 сарын 30 дотор суурилуулж дуусгана.

2.3. Орон нутгийн үйлдвэрийн төсөл

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн Орон нутгийн савласан цэвэр усны үйлдвэрийн ерөнхий гүйцэтгэгчийг 2025.04 сард шалгаруулсан. Барилгын ажил төлөвлөгөөний дагуу суурийн ажил, гадна ханын өрлөг шавар, гадна сэндвич, хана угсралт, дотор бохир, тэгшилгээ, шал цутгалтын ажлууд хийгдэж байна.

2025 оны 09 дугаар сарын 30-ний байдлаар орон нутгийн үйлдвэрийн төсөлд IPO-оос татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6,067,863,875 төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн төслийн барилга угсралтын ажлын явц:

- Газар шороо суурийн ажил, карказ дууссан 100%
- Гадна хананы өрлөг шавар, гадна сэндвич хана угсралт дууссан 100%
- Дээврийн сэндвич угсралтын ажил дууссан 100%
- Дотор бохир, шал, дотор дулааны шугам угсралтын ажил дууссан 100%
- Дотор цахилгааны ажил 70%

Барилга угсралтын ажил шинэчилсэн графикийн дагуу хэвийн явагдаж байна (Зураг 2).



Зураг 2.

	3. IPO хөрөнгийн зарцуулалттай холбоотой хугацаа хойшлох шалтгаан Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр барих төсөл нь анхны төлөвлөгөөний дагуу 2025 онд ашиглалтад орохоор тусгагдсан байсан ч дараах бодит шалтгаануудын улмаас хэрэгжилтийн хугацаа хойшлогдсон. Үүнд: 3.1. Усны нөөцийн хайгуулын хугацаа сунжирсан Өмнөговь аймагт усны геофизикийн болон гидрогеологийн хайгуулын судалгаанууд нь олон үе шаттай, цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд зөвшөөрөл олголт, үр дүнг баталгаажуулах ажиллагаа хойшилсон. 3.2. Байгаль орчны үнэлгээтэй холбоотой шаардлагууд Усны хайгуулын дараах байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх үйл явц нь урьдчилан тооцоолсноос удааширсан. 3.3. Зураг төсөл, тендер шалгаруулалтын хугацаа Үйлдвэрийн барилга, дэд бүтцийн зураг төслийг батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа цаг хугацаа авч, графикаас хоцорсон. 3.4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах, зөвшөөрөл авах үе шат удааширсан Төсөлтэй холбоотой зөвшөөрөл, дэмжлэгийг орон нутгийн байгууллагуудаас авах явцад тодорхой хугацааны зөрүү гарсан. Одоогоор төслийн хэрэгжилт шинэчлэгдсэн графикийн дагуу хэвийн үргэлжилж байна.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	“Эм жи эл акуа” ХК-ийн 2025.02.12 өдрийн ТУЗ-ийн Т/33 тогтоолоор нэгж хувьцаанд 7.31 төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн. 2025 онд ногдол ашгийг бүрэн хуваарилж дууссан.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Төр хувийн хэшилийн хамтын ажиллагааны хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Үйлдвэрийн хаягдал усыг гал унтраах үйлсэд нийлүүлэх) хамтран ажиллах гэрээ байгуулсан - Кристина нобелийн хүүхдийн сан (ажилчдын эрүүл мэнд сэтгэл зүйн боловсрол дээшүүлэх мэргэжлийн сэтгэл зүйн зөвөлгөө сургалт авах) Ажилчдын 2 хүртэлх насны хүүхдийг Монтисорын сургалттай цэцэрлэгт хамруулах. - СХД спорт дугуйн холбоо Монголын хүүхдийн спортын зуны VIII Наадам-д оролцсон хүүхдүүдэд боловсрол спортыг дэмжих зорилгоор бэлэн бүтээгдэхүүний хангамж - Эдийн засгийн ногоон шилжилт төслийн хүрээнд Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Европын холбооны санхүүжилтээр Бэлэн бүтээгдэхүүн дээр Эко тэмдэг авах, БОНЗ олон улсын стандартыг хангах үечилсэн гэрчилгээ авсан. - СХД тохижилт үйлчилгээний хэлтэс СХД 24-р хороотой хамтран Бумбатын рашаанд ногоон зурвас бий болгох хамтарсан ажил хийгдсэн.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:	Овог, нэр:
Албан тушаал: "... " ..К-ийн гүйцэтгэх захирал	Албан тушаал: "... " ..К аудитын компанийн гүйцэтгэх захирал
Гарын үсэг:	Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)	(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026.07.02

Овог, нэр: Г.Намхайдорж
Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
Гарын үсэг:

